



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 52,420,341.00 (тавин хоёр сая дөрвөн зуун хорион мянга гурван зуун дөчин нэгэн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасч Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөхийг зөвшөөрсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Батбаяр, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Г.Ёндон, Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Оюунгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээрр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005809

21-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн
104 дугаар тогтоолын хавсралт



**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Анхны үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл үнэ (төгрөг)
1	Паз автобус 32053-60, 80-76 ОРХ	2010.03.31	52,420,341.00	-
Нийт хөрөнгий дүн			52,420,341.00	-
			(тавин хоёр сая дөрвөн зуун хорин мянга гурван зуун дөчин нэгэн)	-